



Embassy of People's Republic of China to Mongolia



УРИАЛГА: Монгол улсад “Технологи Ашиглан Үйлдэгдэж буй Жендэрт Суурилсан Хүчирхийлэл (ТАҮЖСХ)-тэй тэмцэхэд анхаарлаа хандуулах нь

2024 оны 12-р сарын 2, Улаанбаатар хот

Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ)-тэй тэмцэх 16 хоногийн аяны хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүн Амын Сан болон Азийн сан нь Монгол Улсын Засгийн Газар, Улсын Их Хурлын гишүүн, иргэний нийгмийн байгууллагууд, дипломат төлөөлөгчийн газрууд, олон улсын хөгжлийн байгууллагуудтай хамтран ТАҮЖСХ-тэй тэмцэхэд чиглэсэн дээд түвшний уулзалтыг зохион байгуулж байна. Энэхүү уулзалтанд бэлтгэж, Азийн сан нь Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв (ХЭҮТ) ТББ, Хүний Эрхийн Үндэсний Комисстой (ХЭҮК) хамтран, МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээ, ЛГБТ Төв ТББ, “Хөөрхөн Зүрх” ТББ, "Залуу эрсдэлт бүлгийн манлайлал буюу Youth LEAD Mongolia", Жендэрийн Үндэсний Хорооны төлөөллүүдийг хамруулан [Дэлхий нийтийг хамарсан ТАҮЖСХ-тэй тэмцэх уриалгын](#) хүрээнд Монгол Улсад нутагшуулахад чиглэсэн олон талт уулзалтыг зохион байгуулсан. Монгол дахь уриалгыг олон талт төлөөллүүдэд танилцуулан эцэслэсэн бөгөөд ТАҮЖСХ-тэй тэмцэх уриалгын хүрээнд оролцогч талууд хамтын хүчээ нэгтгэн ажиллах амлалтаа мэдэгдэж, энэхүү асуудалд анхаарах ажлуудыг үйл хэрэг болгохыг дэмжсэн билээ. ТАҮЖСХ нь гэнэт одоо л ил тод болж буй асуудал биш юм. Харин энэхүү хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ажил харьцангуй шинэ байгаа бөгөөд энэ асуудлын талаар хийгдсэн судалгаа, бодлогын баримт бичиг, хөндлөнгийн хяналт, шинжилгээ тун хязгаарлагдмал байна. ЖСХ-ийн бусад төрөлтэй харьцуулахад, цахим орчин дахь хүчирхийлэл нь богино хугацаанд эрчимтэйгээр нэмэгдэж, арга мэх нь улам нарийсч, идэвхжиж байгаа юм. Улмаар энэ төрлийн хүчирхийлэл үйлдэж буй этгээд болон бүлгүүд дижитал орчин дахь иргэний оролцооны аюулгүй байдлыг зөрчиж, хуулийн хариуцлага хүлээхгүй байх явдал гаарсаар байна.

Монгол улсад, ТАҮЖСХ нь цахим орчин дахь иргэдийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж буй ноцтой бөгөөд хурдацтай нэмэгдэж байгаа асуудал мөн. Хэдийгээр Монгол Улс нь Цахим Эрх чөлөөний Эвсэлийн гишүүн улс хэдий ч, улсын хэмжээнд хууль эрхзүй, тогтолцооны хамрах хүрээнд ТАҮЖСХ-ээс иргэдийг хамгаалах зохицуулалт дутмаг, сул байна. Аюулгүй дижитал орчныг дэлгэрүүлэхэд нэн тэргүүнд авах шаардлагатай ажлууд болох хохирогч/даван туулагчдыг хамгаалах цогц үйлчилгээг нэмэгдүүлэх, салбар дундын олон талт хамтын ажиллагааг эрчимжүүлэх зэргийг тусгасан сүүлийн үеийн үнэлгээ судалгаанд үндэслэн энэхүү Уриалгыг боловсруулан хүргүүлж байна.

Нэн тэргүүнд анхаарах чиглэлүүд:

1. **“Хууль тогтоомж ба Засаглалыг сайжруулах”:** Монгол улсад мөрдөгдөж, хэрэгжиж буй хууль, эрх зүйн хувьд ТАҮЖСХ-ийг авч үзсэн тодорхой нарийн зохицуулалт дутмаг улмаас ТАҮЖСХ-ийн хохирогч/даван туулагч нар шударга ёсны дагуу эрхээ эдлэх боломжийг бүрдүүлэх, энэ төрлийн хүчирхийллийн мэдээлэл, бүртгэлийг цуглуулахад бэрхшээлтэй байна. Эдгээр бэрхшээлийг анхааралдаа авч, Монгол Улсын Засгийн Газрыг хууль эрх зүйн хүрээнд ТАҮЖСХ-ийн гэмт хэргийг нарийвчлан тодорхойлох, Будапештын Конвенц зэрэг ОУ-ын конвенцид нэгдэх, ТАҮЖСХ-ийн гэмт хэрэг, хүний эрхийн зөрчлийн тоо мэдээ, бүртгэлийг сайжруулж, ТАҮЖСХ-ийн шинж хэлбэрүүдийг шийдвэрлэхийн тулд тогтмол үнэлгээ хийдэг тогтолцоог бүрдүүлэхийг уриалж байна. Ингэснээр,

шударга ёсыг цогцлоон, хохирогч/даван туулагчдад үзүүлэх цогц дэмжлэгийг нэмэгдүүлэх бат бөх суурь бүрдэнэ.

2. **“ТАҮЖСХ-тэй холбоотой нэр томъёонууд цэгцтэй, зөв тодорхойлогдсон эсэхийг нягтлах, бүх нийтэд хэрэглээ болгохыг ажил хэрэг болгох”**: ТАҮЖСХ-тэй тэмцэхэд зөв, цэгцтэй нэр томъёог нутагшуулан ашиглах нь нэн чухал байна. Засгийн газар болон хамтрагч байгууллагууд ТАҮЖСХ-тэй холбоотой чухал нэр томъёонуудыг хууль эрхзүй, тогтолцооны түвшинд олон улсын стандарттай нийцүүлэн албажуулахыг уриалж байна. Азийн сан болон Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв хамтран боловсруулсан энэхүү “Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэл” гэсэн нэр томъёоны хувилбар нь цаашдын хууль эрхзүйн хүрээнд гаргах шаардлагатай нэр томъёог боловсруулахад дэмжлэг үзүүлэх суурь болно.
3. **“Хуулийн хэрэгжилт, Эрүүгийн шударга ёсыг бэхжүүлэх”**: Энэ төрлийн гэмт хэрэг, хүчирхийлэлтэй тэмцэхэд ТАҮЖСХ-ийн гэмт хэргийг мөрдөн шалгах, цахим нотлох баримт бүрдүүлэх чиглэлээр ажиллах мэргэшсэн боловсон хүчин нэн чухалд тооцогддог. Тиймээс энэ салбарт ажиллах чадварлаг боловсон хүчин татах бодлого явуулахад, бүрэн дүүрэн цэгцтэй мэдлэг олгох сургалт, ТАҮЖСХ-ийн гэмт хэргийг нотлох баримт бүрдүүлэлтийг бэхжүүлэх, үнэлэх программын болон техник хангамжийг сайжруулахад хангалттай санхүүжилт, дэмжлэгийг Монгол Улсын хууль сахиулагчдад үзүүлэхийг зөвлөж байна. Цаашлаад, олон улсын сайн туршлагауудыг нэвтрүүлснээр энэ төрлийн гэмт хэргийг бүртгэх, тодорхойлох, дахин үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдэд хуулийн хариуцлага ногдуулах механизмыг сайжруулах ажлуудыг тусгахыг зөвлөж байна.
4. **“Хохирогч/даван туулагчдад үзүүлэх цогц дэмжлэг”**: ТАҮЖСХ-ийн хохирогч/даван туулагчдад үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмж болон чадавх хангалтгүйгээс болж дэмжлэг туслалцаа авах боломж нэн хомс, цаашлаад дахин хохирогч болох эрсдэлтэй тулгардаг. Уг асуудлыг шийдвэрлэхийн тулд, үндэсний хэмжээнд хохирогч төвтэй тусламж үйлчилгээг сайжруулах, тур дундаа сэтгэлзүйн үйлчилгээний дэмжлэг, гэмт хэргийг бүртгэн шийддэг тогтолцоог хүртээмжтэй болгохыг уриалж байна. Мөн цаашлаад, хохирогчид нөхөн олговор авахад дижитал нотлох баримт ашиглах боломж; бүх нийтийн ТАҮЖСХ-ийн тухай мэдлэг ойлголт; тусламж, үйлчилгээг дэмжих иргэний нийгмийн байгууллагууд болон оролцогч талуудад хүрэх шаардлагатай цогц санхүүжилтийн нөхцөл байдлыг үндэсний хэмжээнд судлахыг зөвлөж байна.
5. **“Нийгмийн ойлголтыг сайжруулах, урьдчилан сэргийлэх мэдлэгийг түгээх”**: ТАҮЖСХ, кибер аюулгүй байдлын талаар иргэдэд хүрэх мэдлэг, мэдээлэл хязгаарлагдмал байгаагаас олон иргэд хохирогч болох өндөр эрсдэлд байна. ТАҮЖСХ-ээс урьдчилан сэргийлэхэд энэ асуудлын талаар цэгцтэй агуулга

боловсруулах, иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх нэн шаардлагатай. Тиймээс, ТАҮЖСХ-ийн төрөл хэлбэр, хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг мэдээлэл, агуулгыг Ерөнхий Боловсролын Сургуулиудын цахим боловсролын хичээлийн хөтөлбөрт тусгах, дижитал хэрэглээний боловсролын агуулгыг гүнзгийрүүлэх, Монгол улсын боловсролын системээр дамжуулан түгээх шаардлагатай.

Цахим орчин дахь аюулгүй байдлын тухай, ТАҮЖСХ-ийн ойлголтын тухай, хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхэд кампанит ажлууд үр нөлөөтэй гэдгийг онцолж байна.

6. **Хувийн хэвшлийг татан оролцуулах:** ТАҮЖСХ-тэй тэмцэхэд хувийн хэвшил, тэр дундаа интернет болон үүрэн холбооны үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын оролцоо, нийгмийн сүлжээний платформууд маш чухал. Холбогдох байгууллагуудын хувь хүний мэдээллийн аюулгүй байдлыг хангах холбогдох стандартууд болон дижитал мөрдөн шинжилгээний үед дэмжих аливаа протоколуудын нөхцөл байдлын судалгаа хийх шаардлага байна. Мөн түүнчлэн, ТАҮЖСХ-ээс урьдчилан сэргийлэх тухай интернет үйлчилгээний байгууллагуудад сургалтуудыг дэлгэрүүлэх хэрэгцээ байна. Бид ТАҮЖСХ-тэй холбоотой хүний эрхийн ноцтой зөрчлүүдтэй тэмцэхэд хувийн хэмшил болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэхийг уриалж байна. Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны зүгээс ТАҮЖСХ-ээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг дэмжих, хариуцлагын тогтолцоог сайжруулахад салбар дундын хамтын ажиллагааг манлайлан оролцох нь чухал ач холбогдолтой байна.
7. **“Мэдлэг ойлголтыг түгээхэд Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтрах”:** Хэвлэл мэдээллийн оролцоо нь хүний эрх, ёс зүйн хэм хэмжээг чандлан сахих, хүний эмзэг, хувийн мэдээллийг хамгаалах, ТАҮЖСХ-ийн тухай олон нийтэд хүртээлтэй ойлголтыг нэмэгдүүлэх, энэ төрлийн хүний эрхийн зөрчилтэй бүх нийтээрээ тэмцэхэд нэн чухалд тооцогддог. Хэвлэл Мэдээллийн Зөвлөлтэй хамтран, бусад хэвлэл мэдээллийн байгууллагуудыг ТАҮЖСХ-ийн асуудлыг нэн тэргүүний асуудалд тооцож, энэ төрлийн мэдлэг, мэдээлэл авах, урьдчилан сэргийлэх, дижитал орчин дахь аюулгүй байдлыг өөрсдийн сүлжээндээ нэвтрүүлэхийг зөвлөж байна. Тухайлбал ТАҮЖСХ-д тусгайлан анхаарсан “Медиа Хакатон” сарыг зохион байгуулж, шинэ бүтээлч шийдэл гаргахад салбарын мэргэжилтнүүд, ажилтнуудыг идэвхжүүлэх боломжтой.
8. **ЛГБТИК+ олон нийт болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрэх мэдээллийн хүртээмжийг сайжруулах:** ЛГБТИК+ болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд ТАҮЖСХ-ийг мэдээлэхэд олон бэрхшээлтэй тулгардаг. Бид, ТАҮЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийг шаардлагатай мэдлэг, мэдээллийг хүн бүхэнд хүртээмжтэй, онцлог хэрэгцээнд нийцсэн байхад анхаарч, дотоодын байгууллагуудыг хамтран ажиллахад уриалж байна.

9. Хүний Эрхийн Үндэсний Комисс/ХЭҮК/-ийн зүгээс хэрэгжүүлж буй Олон Талт Хамтын ажиллагааг дэмжих:

Азийн сан, ХЭҮК, ХЭҮТ-өөс хамтран зохион байгуулсан “ТАҮЖСХ-тэй тэмцэхэд салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэх нь” олон талт төлөөллийн уулзалтаар төр, иргэний нийгмийн 50 гаруй мэргэжилтнүүд уг асуудлаар олон нийт, төр, төрийн бус байгууллагуудын салбар дундын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, ялангуяа мэдээлэл солилцох тогтолцоог бүрдүүлж, хамтран ажиллах шаардлагатай байгааг онцолсон. Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2025 оны эхээр УИХ-д өргөн барих Хүний Эрх, Эрх Чөлөөний Байдлын Талаарх 24 дэх илтгэлдээ Монгол Улсын цахим хөгжлийн бодлого, шинээр хэрэглэнд нэвтэрч буй технологийн хүний эрх, эрх чөлөө, тэр дундаа охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй ЖСХ-д үзүүлж буй нөлөө, энэхүү асуудлыг шийдвэрлэхэд салбар дундын олон талт хамтын ажиллагаа онц ач холбогдолтой бөгөөд түүнийг эрчимжүүлэх шаардлагатай байгааг онцлон танилцуулах юм.

Иймд, Монгол Улсад хүн бүрт илүү аюулгүй, хүртээмжтэй дижитал орон зайг цогцлоохын төлөө Засгийн Газар, иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын үйл хэргийг бэхжүүлцгээе. Технологи нь биднийг аюулд оруулахаас илүүтэй бидэнд эерэг үр өгөөжтэй байхад анхааран яг одооноос хамтран ажиллацгаая.

Уриалгад хэрхэн нэгдэх вэ?

- **Гарын үсгээ зурах:** Монгол улсад ТАҮЖСХ-тэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхийг шаардахад таны хувь нэмэр чухал байна.
- **Уриалгыг хуваалцах:** Цахим болон нийгмийн сүлжээнд энэ тухай мэдлэг, мэдээлэл түгээх, бусдыг уриалахдаа *#MongoliaAgainstTFGBV*-г ашиглах.
- **Цогц санхүүжилтийг дэмжих:** ТАҮЖСХ-тэй тэмцэх Уриалгын дор санаачлага гарган ажиллаж буй байгууллагуудыг дэмжин, хувь нэмрээ оруулан хамтран ажиллах.